



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7, 9.1.20, Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан тус хорооны дүрмийн 5.2.6 дах заалтуудыг үндэслэн, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн саналыг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ НЬ**:

1. “Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг төвлөрсөн дулаан хангамжид холбогдон дулааны эрчим хүчээр хангагдаж байгаа аж ахуйн нэгж, айл өрхийн дулааны төлбөр тооцоонд 2015 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын гүйцэтгэх захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчuluun/-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн “Журам батлах тухай” 2008 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 158, 2009 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоолууд, 2011 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн “Хэрэгцээний халуун ус халаасан дулааны төлбөрийг тогтоох тухай” 95 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ


ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР



## ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дулааны эрчим хүч дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид /цаашид “дамжуулагч, түгээгч, хангагч” гэнэ/, хэрэглэгчийн хооронд дулааны эрчим хүчиний төлбөр тооцоог хийхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү журмыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төвлөрсөн дулаан хангамжид холбогдон үйл ажиллагаа явуулж байгаа дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгчид мөрдөнө.

1.3. Хангагч, хэрэглэгч нь хууль тогтоомжид нийцүүлэн дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулна.

### Хоёр. Нэр томьёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 “**халаалт тооцох эзлэхүүн**” гэж төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга объектын нийт эзлэхүүнийг;

2.1.2 “**орон сууц**” гэж Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг;

2.1.3 “**орон сууцанд оршин суугч**” гэж төвлөрсөн дулаан хангамжаас дулааны эрчим хүчээр хангаж байгаа орон сууцанд нэг сар буюу түүнээс дээш хугацаагаар түр буюу байнга оршин сууж байгаа иргэнийг;

2.1.4 “**хянагдсан зураг төсөл**” гэж дулаан хангамжийн шугам, тоноглолын хүчин чадал түүнтэй холбоотой тооцоог хангагчийн эрх бүхий ажилтан хянаж баталгаажуулсан барилгын зургийг;

2.1.5 “**халаалт тооцох подвал**” гэж үйлдвэрлэл, үйлчилгээний /дэлгүүр, нийтийн хоолны газар, үсчин болон бусад/ чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор орон сууцны барилгын зоорийн болон хаяавчийн давхрын тохижуулсан өрөө тасалгааг;

2.1.6 “**халаалт тооцох 0 өрөө**” гэж орон сууцны барилгын техникийн зориулалтын өрөө тасалгааг хүн амьдран суухаар болон аж ахуйн үйл ажиллагаа явуулахаар өөрчлөн ашиглаж байгаа халаах хэрэгсэл бүхий өрөөг;

## **Гурав. Ерөнхий нөхцөл**

3.1. Дулааны эрчим хүчээр хангах, худалдан авах тухай гэрээнд тусгагдсан дулааны тоолуур, усны тоолуурын заалт, барилгын эзлэхүүн, талбай, дулааны тоног төхөөрөмжийн зураг төслийн тооцоот хүчин чадал, хүний тоо нь төлбөрийн тооцоо хийх үндэслэл болно.

3.2. Хэрэгцээний халуун усны хүчин чадал нь зураг төсөлд тусгагдаагүй бол Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолыг үндэслэнэ.

3.3. Дулааны тоолуургүй, эсхүл усны тоолуургүй хэрэглэгчийн салхилуулга, ахуйн ба технологийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны эрчим хүчийг тодорхойлохдоо тухайн барилга объектын хянагдсан зураг төслийн хүчин чадлын 75 хувиар тооцно.

3.4. Өөрийн тусгайлсан зураг төслөөр баригдсан барилга, объект бүхий дулааны тоолуургүй, эсхүл усны тоолуургүй хэрэглэгчдэд энэ журмын 3.3. дах заалт нэгэн адил хамаарна.

3.5. Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилга, объектын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг тогтоохдоо тухайн барилгын гадна болон өрөөний хана, тааз, шалны зузааны тэнхлэгээс эсрэг талын гадна болон өрөөний хана тааз, шалны зузааны тэнхлэг хүртэлх зайгаар тодорхойлно. Анхны батлагдсан зургаас өөр зориулалтаар уг барилгыг ашиглах бол мэргэжлийн байгууллагын дүгнэлт, дулааны эрчим хүчээр найдвартай хангах техникийн хувьд боломжтой эсэх тооцоог үндэслэн эх үүсвэрийг тогтооно.

3.6. Айл өрхийн халаалтын төлбөр тооцох талбайг Монгол Улсын MNS 6058:2009 стандарт /Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал/-д заасан сууцны зориулалттай болон сууцны бус зориулалттай талбайн нийлбэрээр тогтооно. Уг стандартыг үндэслэн айл өрхийн халаалт тооцох талбайн хэмжилтийг хийнэ.

3.7. Халаах хэрэгсэлгүй боловч бусад халаах хэрэгсэл бүхий өрөө, тасалгааны дулаан солилцоогоор халж хэвийн үйл ажиллагаа явуулах орчин бүрдсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй барилгын халаалтыг эзлэхүүнээр, орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа барилгын халаалтыг талбайгаар тооцно.

3.8. Орон сууцны барилгын орцны халаалтын төлбөрийг халаах хэрэгсэл бүхий давхрын талбайн хэмжигдэхүүнээр тооцон тухайн барилгын ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллага хариуцна.

3.9. Талбайн хэмжигдэхүүнээр дулааны эрчим хүчний төлбөр тооцогдож байгаа аливаа барилга, байгууламж, орон сууцанд аж ахуйн үйл ажиллагаа явуулсан нөхцөлд тухайн хэсгийн дулааны төлбөрийг эзлэхүүнээр тооцно.

3.10. Хэрэглэгч нь дулааны эрчим хүчний төлбөрийг тухайн сард нэхэмжлэлийн дагуу төлнө. Энэ хугацаанд дулааны төлбөрөө барагдуулаагүй үнийн дүнд Иргэний хууль, Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалтын дагуу 0.5 хүртэл хувь хэмжээгээр тооцож алданги ногдуулна.

3.11. Тухайн сард төлсөн төлбөрийг тооцохдоо урьд сард гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй төлбөрийн үлдэгдэл болон алдангийг эхний ээлжид төлснөөр тооцон суутгаж зөрүүг тухай сарын төлбөрт тооцно.

3.12. Хэрэглэгч төлбөр тооцооны талаар маргаантай асуудлаар санал, хүсэлтээ дараа сарын 10-ны дотор албан бичгээр тавьж шийдвэрлүүлнэ.

3.13. Дулаан хангамжийн горимын зөрчил, шугам тоног төхөөрөмжийн гэмтэлтэй холбоотой хэрэглэгчийн санал гомдлыг 7 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.

3.14. Хэрэглэгч дулаанаар хангагдах барилга байгууламжийн эзлэхүүн, талбай, хэрэгцээний халуун усны ачааллыг гэрээнд зөв тусгуулаагүй болон холболтыг өөрчлөх, эзлэхүүн, талбайг нэмэх, багасгасан нь илэрсэн бол энэ тухай акт үйлдэн дээрх зөрчилд нөхөн төлбөр ногдуулна. Нөхөн төлбөрийг тооцох хугацааг тодорхойлох боломжтой бол холбогдох баримтыг хавсаргах ба хугацааг тодорхойлох боломжгүй нөхцөлд дулаан авахаар гэрээнд заасан хугацаанаас эхлэн нөхөн төлбөр ногдуулна.

3.15. Дулааны үйлчилгээний тарифыг халаалтын төлбөр тооцох талбайн хэмжээнд үндэслэн тогтооно.

3.16. Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их засварын үед хэрэгцээний халуун усаар хэрэглэгчийг хязгаарласан тохиолдолд хязгаарласан хоногт ногдох дулааны үйлчилгээний тарифыг тухайн сарын дулааны үйлчилгээний тарифаас хасаж тооцно.

## **Дөрөв. Тоолууртай хэрэглэгчийн төлбөр тооцох**

4.1. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3-т заасан шаардлагыг хангасан дулааны тоолуурыг дулааны эрчим хүчний төлбөр тооцоонд ашиглах бөгөөд усны тоолуурыг хэрэгцээний халуун ус халаасан дулааны төлбөр тооцоонд ашиглана.

4.2. Дулааны тоолуурыг тооцоонд авахдаа дараах материалын бурдлийг хангасан байна.

- 4.2.1 тоолуур сууринуулсан протокол
- 4.2.2 72 цагийн туршилт хийсэн хэмжилтийн бичилт
- 4.2.3 тооцоонд хүлээж авсан тухай акт
- 4.2.4 баталгаажилтын гэрчилгээ

4.3. Хангагчийн эрх бүхий ажилтан нь тухайн хэрэглэгчийн тоолуурын лац ломбоны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянаж сард 4-өөс доошгүй удаа тоолуурын тооцооны хуудас дээр параметрийн тэмдэглэгээ хийж хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулна. Энэхүү хуудсыг үндэслэн сарын төлбөр тооцоог хийх бөгөөд үүнээс гадна энэ нь буцах усны температурын өндөржилтийг тооцох үндсэн баримт болно.

4.4. Дулааны эрчим хүчний тооцоог тоолуураар хийж байгаа хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээн дээр “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийг үндэслэн дулааны шугамын алдагдлыг 5% нэмж тооцно.

4.5. Дулааны эрчим хүчээр хангагдаж байгаа хэрэглэгч нь сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4 хэмээс дээш хэмжээгээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ногдох ашиглахгүй буцаасан дулааны үнийг тооцож буцах усны температур өндөржсөнд ногдох дулааны төлбөрийг бусад хэрэглэсэн дулааны төлбөрийн нэгэн адил төлүүлнэ.

4.6. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад холболт, тохируулгын буруутай үйлдэл, тоолуурыг дур мэдэн таслах, лац ломбо гэмтээсэн болон гадны нөлөөллөөр заалт буруу гарсан бол тоолуурын заалтыг хэрэгсэхгүй болгон төлбөрийг зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн /задгайгаар/ нөхөн тооцно.

4.7. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад гэмтэх, эвдрэх, тоолуурын тэжээлийн доголдол гарах нь хэрэглэгчээс шалтгаалаагүй болохыг хэмжүүрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоосон тохиолдолд усны тоолуураар тооцдог бол өмнөх 3 сарын дунджаар, дулааны тоолуураар тооцдог бол халаалтын улиралд /тухайн хэрэглэгчийн дулааны ачаалалд өөрчлөлт ороогүй бол/ өмнөх оны тухайн сарын дулааны хэмжээг гадна агаарын температураас хамааруулан, халаалтын бус улиралд тухайн улирлын хамгийн их хэрэглээгээр тус тус нөхөн тооцно.

4.8. Шинээр суурилуулсан болон өөрчлөн сольсон дулааны тоолуурыг 72 цагийн туршилт хийж, тооцоонд хүлээж авсан тухай актыг үндэслэн төлбөр тооцоонд ашиглана.

4.9. Тоолуурыг баталгаажуулах болон бусад шалтгаанаар салгах бол хангагч, хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийг байлцуулан лац, ломбоны бүрэн бүтэн байдал болон бусад зүйлийг шалган акт үйлдэнэ.

4.10. Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж дээр суурилуулсан нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэлт устай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчээс тооцон авна.

#### **Тав. Тоолуургүй хэрэглэгчийн төлбөр тооцох**

5.1. Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү журамд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно.

5.2. Орон сууцны барилгын подвалд халаах хэрэгсэл суурилагдсан бол дулааны эрчим хүчний төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Халаах хэрэгсэлгүй боловч уг подвалыг /тараалтын шугамтай/ иргэн, аж ахуйн нэгж эзэмшин ашиглаж байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр тооцно.

5.3. Орон сууцны подвалын хэсгийг автомашины гаражийн зориулалтаар ашиглаж байгаа бол дулааны төлбөрийг талбайн хэмжигдэхүүнээр тооцно.

5.4. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын зориулалтыг өөрчлөн тусгайлан хаалга гадагш гаргаж аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа бол үйл ажиллагаа явуулж байгаа талбайгаас эзлэхүүнээр, бусад хүн амьдарч буй талбайгаас талбайн хэмжигдэхүүнээр тооцно.

5.5. Тусгайлан гадагш хаалга гаргалгүйгээр орон сууцандaa өргөтгөл хийж талбайгаа томсгон хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа бол эзлэхүүнээр тооцно.

----- oOo -----